



СОНИРХОГЧ ЭТГЭЭД НАРТ

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК

16 тоот, 14 давхар, Моннис цамхаг,
Чингисийн өргөн чөлөө 15, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14240
Утас/Факс: (976) 7007 8085, Цахим хуудас: www.eot.mn

2024.08.12 № 01/163

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

“Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тендер хүлээн авах эцсийн хугацааг хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т ажлын 20-иос дээш өдөр байхаар заана гэсний дагуу ажлын 30 өдрөөр тогтоосон.

Таны ирүүлсэн тендер нээх хугацааг 21 хоногоор сунгуулах тухай хүсэлт нь мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 20 дугаар зүйлийн 20.6, 57 дугаар зүйлийн 57.6, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалын хавсралт “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь заалтуудтай нийцэхгүй байх тул тендер хүлээн авах хугацааг сунгах боломжгүй байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ГАНХҮҮ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

0000000429